



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 2018 ОНЫ ЭХНИЙ УЛИРЛЫН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот

2018 он

АГУУЛГА

Оршил	4
Нэг. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ	6
1.1. ДНБ, оны үнээр.....	6
1.2. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр.....	6
1.3. ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцоо.....	7
1.4. Улирлын нөлөөллийг арилгасан ДНБ.....	8
1.5. Эдийн засагт голлох салбаруудын үйлдвэрлэл	8
2. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ	17
2.1. ДНБ, оны үнээр.....	17
3.1. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр.....	18

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр.....	6
Хүснэгт 2. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	6
Хүснэгт 3. ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцоо, пунктээр.....	7
Хүснэгт 4. Бойжуулсан төл, том малын зүй бүс хорогдол	8
Хүснэгт 5. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	9
Хүснэгт 6. Уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	9
Хүснэгт 7. Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	11
Хүснэгт 8. Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	12
Хүснэгт 9. Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр	12
Хүснэгт 10. Дотоод худалдааны борлуулалт, импортын хэмжээ.....	13
Хүснэгт 11. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт	14
Хүснэгт 12. Шуудан, холбооны салбарын үндсэн үзүүлэлт	14
Хүснэгт 13. Зочид буудал, нийтийн хоолны салбарын орлого, оны үнээр	15
Хүснэгт 14. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, хугацааны эцэст.....	15
Хүснэгт 15. Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого	16
Хүснэгт 16. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, оны үнээр	17
Хүснэгт 17. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр.....	18
Хүснэгт 18. Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд	19

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ДНБ-ий өсөлт (%), (2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх оны мөн үеэс)	5
Зураг 2. ДНБ-ий өсөлтөд салбарын оролцоо, 2018 оны эхний улирал (пункт)	5
Зураг 3. ДНБ-ий зардлын өсөлт (%)	5
Зураг 4. ДНБ-ий өсөлтөд бүрэлдэхүүн хэсгүүдийн оролцоо, 2018 оны эхний улирал (пункт)	5
Зураг 5. ДНБ-ий өсөлт, уул уурхайн болон уул уурхайн бус салбараар, хувиар	7
Зураг 6. ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр)-д салбаруудын оролцоо, өсөлт, бүүралт	7
Зураг 7. ДНБ (улирлын нөлөөллийг арилгасан)-ий өсөлт, хувиар (2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх улирлаас)	8
Зураг 8. Уул уурхайн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт, экспорт	10
Зураг 9. Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, импорт	12
Зураг 10. Дотоод худалдааны борлуулалт, импортын хэмжээ	13
Зураг 11. Тээврийн салбарын орлого	14
Зураг 12. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий бүтэц, дүнд эзлэх хувиар	17
Зураг 13. ДНБ-ий өсөлтөд бүрэлдэхүүн хэсгүүдийн оролцоо (пункт)	18

Товчилсон үг

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮ	Нийт үйлдвэрлэл
НӨ	Нэмэгдэл өртөг
ӨҮАББ	Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

Тайлбар

¹ ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо

* Урьдчилсан гүйцэтгэл

Оршил

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тайлант хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцно. Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж, нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг үйлдвэрлэлийн; эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспорт (экспорт, импортын зөрүү)-ын нийлбэрээр тооцохыг эцсийн ашиглалтын; ажиллагчдын цалин хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар (үйлдвэрлэл, импортын татвар, татаасын зөрүү), үйл ажиллагааны цэвэр ашиг/холимог орлого зэрэг орлогын үзүүлэлтийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэж нэрлэнэ.

ДНБ-ийг улирлаар үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар тооцно. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ нь шинээр бий болсон нэмэгдэл өртөг аль салбарт бий болсныг харуулах бол эцсийн ашиглалтын аргаарх ДНБ нь үйлдвэрлэгчдийн бий болгосон нэмэгдэл өртгийг зах зээлийн арилжаа солилцооны эцэст хаана, ямар хэлбэрийн өртөг болгож ашигласныг харуулна. Энэ нь өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал, бараа үйлчилгээний цэвэр экспорт гэсэн дэд хэсгүүдээс бүрдэнэ.


Мөн эдийн засгийн бодит өсөлтийг үнийн өсөлтийн нөлөөллийг арилгасан буюу зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий өөрчлөлтөөр тодорхойлно. Эдийн засгийн орчин, салбарын бүтцэд гарах өөрчлөлт нь суурь оныг тодорхой давтамжтай өөрчлөх үндэслэл болдог.

Уг танилцуулгад ДНБ-ий үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын аргаар тооцсон үр дүнгүүд болон ДНБ-тэй холбоотой макро-эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүдийг тусгасан.

Эдийн засаг 2018 оны эхний улиралд 6.1 хувиар өслөө

Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2017 онд өмнөх оноос 5.1 хувиар өссөн бол 2018 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өслөө.

Зураг 1. ДНБ-ий өсөлт (%), (2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх оны мөн үеэс)




ДНБ-ий 2018 оны эхний улирлын өсөлтөд бүтээгдэхүүний цэвэр татвар өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 1.9 пунктийг, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг (НӨ) өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 1.5 пунктийг бүрдүүлсэн байна. Мөн уул уурхайн салбарын НӨ 4.2 хувиар өссөн бөгөөд ДНБ-ий өсөлтөд 1.1 пунктийн оролцоотой байна.

Зураг 2. ДНБ-ий өсөлтөд салбарын оролцоо, 2018 оны эхний улирал (пункт)



Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2017 онд өмнөх оноос 5.1 хувиар өссөн бол 2018 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өслөө.

Зураг 3. ДНБ-ий зардлын өсөлт (%)



Өрхийн аж ахуйн болон ӨҮАББ-ын эцсийн хэрэглээ 2018 оны эхний улиралд 9.6 хувиар өссөн. Энэ нь ДНБ-ий нийт өсөлтөд 6.1 пунктийн оролцоотой байна. Төрийн байгууллагын хэрэглээ 5.7 хувиар өсөж, нийт өсөлтөд 0.9 пунктийн оролцоотой байна. Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал 48.1 хувийн өсөлттэй бөгөөд нийт өсөлтөд 9.6 пунктийг бүрдүүлсэн байна. Экспорт 18.6 хувь, импорт 26.9 хувиар нэмэгдэж, цэвэр экспорт нийт өсөлтийн(-10.8) пунктийг бүрдүүлжээ.

Зураг 4. ДНБ-ий өсөлтөд бүрэлдэхүүн хэсгүүдийн оролцоо, 2018 оны эхний улирал (пункт)



Нэг. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ

1.1. ДНБ, оны үнээр

ДНБ, оны үнээр 2018 оны эхний улиралд 6.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 918.4 (16.1%) тэрбум төгрөгөөр өслөө.

Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр

	2015	2016 ¹	2017*	2018*	<u>2015 I-III</u>	<u>2016¹ I-III</u>	<u>2017* I-III</u>	<u>2018* I-III</u>
	I-III	I-III	I-III	I-III	2014 I-III	2015 I-III	2016 ¹ I-III	2017* I-III
	тэрбум төгрөг				хувиар			
ДНБ	4 643.5	4 737.2	5 707.8	6 626.2	110.0	102.0	120.5	116.1
Хөдөө аж ахуй	169.2	181.0	187.9	199.6	100.4	107.0	103.9	106.2
Уул уурхай, олборлолт	880.0	931.7	1 519.0	1 828.6	102.4	105.9	163.0	120.4
Аж үйлдвэр, барилга	616.5	630.8	716.4	848.4	119.7	102.3	113.6	118.4
Үйлчилгээ	2 535.7	2 543.7	2 740.9	2 997.2	114.7	100.3	107.8	109.4
Бүтээгдэхүүний цэвэр татвар	442.1	450.0	543.6	752.4	94.4	101.8	120.8	138.4

1.2. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр


ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны эхний улиралд 3.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 188.0 (6.1%) тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 74.8 (4.9%) тэрбум төгрөг үүнээс бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 25.8 (7.3%) тэрбум төгрөг, бүтээгдэхүүний цэвэр татвар 56.8 (16.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Хүснэгт 2. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

	2015	2016 ¹	2017*	2018*	<u>2015 I-III</u>	<u>2016¹ I-III</u>	<u>2017* I-III</u>	<u>2018* I-III</u>
	I-III	I-III	I-III	I-III	2014 I-III	2015 I-III	2016 ¹ I-III	2017* I-III
	тэрбум төгрөг				хувиар			
ДНБ	2 852.8	2 937.3	3 059.7	3 247.7	104.2	103.0	104.2	106.1
Хөдөө аж ахуй	117.2	122.2	127.3	127.8	110.5	104.3	104.2	100.3
Уул уурхай, олборлолт	703.9	813.6	763.8	796.3	113.4	115.6	93.9	104.2
Аж үйлдвэр, барилга	278.6	270.1	294.3	317.8	111.4	97.0	109.0	108.0
Үйлчилгээ	1 448.9	1 433.4	1 521.4	1 596.2	103.4	98.9	106.1	104.9
Бүтээгд. цэвэр татвар	304.2	298.0	352.9	409.7	84.3	98.0	118.4	116.1

ДНБ-ийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр уул уурхайн болон уул уурхайн бус салбарын гэж ангилан харуулбал, уул уурхайн салбар 2015 онд 13.4 хувиар, 2016 онд 15.6 хувиар тус тус өсжээ. 2017 оны эхний улиралд 6.1 хувиар буурсан ч эдийн засаг 4.2 хувиар өссөн байна. Харин 2018 оны эхний улиралд уул уурхайн салбар 4.2 хувийн өсөлттэй болж, эдийн засаг 6.1 хувиар өслөө.

Зураг 5. ДНБ-ий өсөлт, уул уурхайн болон уул уурхайн бус салбараар, хувиар



1.3. ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцоо

Хүснэгт 3. ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцоо, пунктээр

	2016 ¹				2017*				2018*
	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III
ДНБ-ий өсөлт, %	3.0	1.5	-1.4	1.2	4.2	5.3	5.8	5.1	6.1
Хөдөө аж ахуй	0.2	0.7	0.6	0.8	0.2	0.6	0.7	0.3	0.0
Уул уурхай, олборлолт	3.8	1.9	-0.1	0.0	-1.7	-1.4	-0.5	-1.7	1.1
Боловсруулах	-0.7	-0.7	-0.4	-0.1	1.2	1.1	1.2	1.3	0.4
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.1	0.1	0.0	0.0	0.1	0.1	0.1	0.1	0.3
Барилга	0.4	0.2	-0.4	-0.2	-0.4	-0.4	-0.4	0.0	0.1
Бөөний, жижиглэн худалдаа	-0.4	0.1	-0.8	-0.3	1.8	1.3	1.2	1.2	0.8
Тээвэр, мэдээлэл, холбоо	-0.3	0.0	0.1	0.7	1.0	1.1	1.0	1.3	0.1
Үйлчилгээний бусад	0.2	0.1	0.0	0.2	0.2	0.6	0.6	1.0	1.5
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-0.2	-0.9	-0.4	0.0	1.9	2.2	1.9	1.6	1.9

2018 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн өртгийн албан татвар (оны үнээр) 26.3 хувь, онцгой албан татвар (оны үнээр) 64.5 хувиар нэмэгдсэнтэй холбогдон бүтээгдэхүүний цэвэр татварт өсөлт гарсан. Түүнчлэн уул уурхай, олборлолтын салбарын үйл ажиллагаа нэмэгдсэнтэй холбогдон үйлчилгээний салбаруудад өсөлт гарсан байна.


Зураг 6. ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр)-д салбаруудын оролцоо, өсөлт, бууралт



1.4. Улирлын нөлөөллийг арилгасан ДНБ

Улирлын нөлөөллийг арилган тооцсоноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны эхний улиралд өмнөх улирлаас 1.6 хувиар өслөө.

Зураг 7. ДНБ (улирлын нөлөөллийг арилгасан)-ий өсөлт, хувиар (2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх улирлаас)



1.5. Эдийн засагт голлох салбаруудын үйлдвэрлэл

Хөдөө аж ахуйн салбар

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2018 оны эхний улиралд ДНБ-ий дүнд 3.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар өссөн байна.

Улсын хэмжээнд 2017 оны эцэст тоологдсон төллөх насны хээлтэгч малын 4.3 сая (15.4%) нь 2018 оны эхний улиралд төллөсөн байна. Гарсан төлийн 97.4 хувь буюу 4.2 сая төл бойжиж, өмнөх оны мөн үеэс 1.2 (-22.2%) саяар буурсан байна. Том малын зүй бус хорогдол 2018 оны эхний улиралд улсын хэмжээнд 1.1 сая болж, өмнөх оны мөн үеэс 847.9 (4.1 дахин) мянгаар өссөн байна.

Хүснэгт 4. Бойжуулсан төл, том малын зүй бус хорогдол

Үзүүлэлт	2015	2016	2017	2017 I-III	2018* I-III	<u>2018* I-III</u> 2017 I-III
	мянган толгой					хувиар
Малын тоо, оны эхэнд	51 982.5	55 979.7	61 549.2			
Бойжуулсан төл	19 179.5	19 721.7	22 612.6	5 454.7	4 242.4	77.8
Том малын зүй бус хорогдол	625.6	1 452.1	826.5	269.0	1 116.9	415.2
Хүнсэнд хэрэглэсэн мал	14 556.7	12 700.0	14 468.7			
Малын тоо, оны эцэст	55 979.7	61 549.2	66 219.0			

Аж үйлдвэрийн салбар

Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2018 оны эхний улиралд ДНБ-ий өсөлтийн 1.7 пунктийг бүрдүүлж, өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл (оны үнээр) 2018 оны эхний улиралд 3273.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 584.3 (21.7%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

Аж үйлдвэрийн салбар	2015	2016	2017	2018*	<u>2016 I-III</u>	<u>2017 I-III</u>	<u>2018*I-III</u>
	I-III	I-III	I-III	I-III	2015 I-III	2016 I-III	2017 I-III
	тэрбум төгрөг				хувь		
Нийт дүн	1 762.5	1 805.9	2 688.9	3 273.2	102.5	148.9	121.7
Уул уурхай, олборлох	1 131.6	1 200.5	1 962.2	2 362.5	106.1	163.4	120.4
Боловсруулах	411.7	346.8	464.2	605.7	84.2	133.9	130.5
Цахилгаан, дулаан, ус хангамж	219.3	258.7	262.5	305.0	118.0	101.5	116.2

➤ Уул уурхай, олборлох салбар

Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эхний улиралд 2362.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 400.3 (20.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр


	2015	2016	2017	2018*	Бүтэц		
					2016 I-III	2017 I-III	2018*I-III
	I-III	I-III	I-III	I-III	хувь		
	тэрбум төгрөг				хувь		
Нийт дүн	1 130.4	1 200.5	1 962.2	2 362.5	100.0	100.0	100.0
Нүүрс олборлолт	192.0	166.1	570.2	784.4	13.8	29.1	33.2
Газрын тос олборлолт	174.0	153.2	228.3	260.5	12.8	11.6	11.0
Металлын хүдэр олборлолт	753.0	874.9	1 141.2	1 291.7	72.9	58.2	54.7
Бусад ашигт малтмал олборлолт	11.5	6.3	22.4	25.9	0.5	1.1	1.1

Уул уурхай, олборлох салбарт дэд салбаруудын эзлэх хувь хэмжээг харьцуулбал, нүүрс олборлох салбарын эзлэх хувь өсөж, харин газрын тос болон металлын хүдэр олборлох салбарын эзлэх хувь буурчээ.

Манай улс экспортод гол төлөв уул уурхайн салбарын бүтээгдэхүүнийг гаргаж байна. Нүүрс олборлолтын хэмжээ 2018 оны эхний улиралд 11.2 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 500.5 (-4.3 хувь) мянган тонноор буурч, харин нүүрсний экспортын хэмжээ 2018 оны эхний улиралд 6.8 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.4 (-16.8 хувь) сая тонноор буурсан байна.

Төмрийн хүдрийн хувьд 2018 оны эхний улиралд олборлолт өмнөх оны мөн үеэс 83.9 хувиар, экспорт 30.2 хувиар өсжээ.

Зураг 8. Уул уурхайн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт, экспорт



➤ *Боловсруулах салбар*

Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эхний улиралд 605.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 141.4 (30.5%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

Дэд салбар гол нэр төрлийн бүтээгдэхүүн	2015	2016	2017	2018*	2017 I-III	2018* I-III
	I-III	I-III	I-III	I-III	2016 I-III	2017 I-III
	тэрбум төгрөг				хувь	
Нийт дүн	421.1	346.8	464.2	605.7	133.9	130.5
Хүнс, ундаа үйлдвэрлэл	230.8	219.2	258.2	320.6	117.8	124.2
Малын мах, мян.т	4.2	1.4	2.1	1.2	152.5	57.8
Гурил, мян.т	48.9	38.0	56.9	62.4	149.8	109.7
Спирт, сая л	2.1	2.4	2.5	2.7	106.2	104.2
Архи, дарс, сая л	5.2	5.3	6.1	7.7	116.0	125.2
Шар айраг, сая л	16.1	15.1	17.7	19.1	116.9	108.3
Тамхи үйлдвэрлэл	3.6	-	3.1	5.4	-	172.9
Тамхи, мян.блок	240.6	-	652.3	957.5	-	146.8
Нэхмэлийн үйлдвэрлэл	49.5	45.2	56.5	73.0	125.0	129.3
Хивс, мян.м2	176.9	84.5	100.2	95.8	118.6	95.6
Самнасан ноолуур, т	67.5	71.2	51.2	53.2	71.9	103.9
Эсгий, мян.м	23.5	8.1	15.0	18.2	185.2	121.3
Хувцас үйлдвэрлэл	7.2	4.9	9.0	9.7	183.6	107.4
Нэхий дээл, ш	2 411	1 818.0	4 799.0	1 943.0	2.6 ¹	40.5
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал	5.6	3.4	4.5	5.0	133.9	110.5
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	1.4	2.7	3.2	4.6	120.6	142.3
Зүсмэл материал, мян.м3	4.9	2.4	2.5	3.0	105.8	118.2
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1.9	2.0	3.4	4.5	170.0	133.8
Нийтлэх, хэвлэх үйл ажиллагаа	5.4	5.9	5.9	7.5	99.6	126.7
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	33.5	27.4	62.0	85.4	2.3 ¹	137.7
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10.6	8.0	16.4	19.7	2.1 ¹	119.7
Резин, хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7.4	4.6	4.3	4.7	95.1	108.0
Вакуум цонх, хаалга, мян.м2	9.7	3.4	4.3	4.5	125.5	104.4
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	8.2	6.3	8.7	18.6	137.0	2.2 ¹
Цемент, мян.т	22.3	10.8	23.0	70.4	2.1 ¹	3.1 ¹
Шохой, мян.т	8.5	4.0	15.0	5.4	3.8 ¹	36.0
Төмрийн үйлдвэрлэл	42.3	14.1	25.6	43.2	182.2	168.4
Металл цувимал, мян.т	11.9	-	2.8	7.7	-	2.8 ¹
Катодын зэс, мян.т	3.5	3.8	3.7	3.6	98.5	95.7
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	0.8	0.4	0.5	0.6	119.5	123.7
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	0.0	0.1	0.1	0.1	83.0	192.0
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	0.3	0.2	0.4	0.3	2.1 ¹	83.7
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	0.6	0.5	0.8	0.9	142.2	124.2
Тавилга үйлдвэрлэл, бусад	2.8	1.8	1.5	1.5	87.0	99.1

¹– дахин их

➤ *Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбар*

Цахилгаан эрчим хүч болон усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эхний улиралд 305.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 42.5 (16.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

Дэд салбар	2015	2016	2017	2018*	2017 I-III	2018* I-III
	I-III	I-III	I-III	I-III	2016 I-III	2017 I-III
	тэрбум төгрөг				хувь	
Нийт дүн	219.3	258.7	262.5	305.0	101.5	116.2
Цахилгаан, дулаан, уур	200.9	240.3	243.2	284.2	101.2	116.8
Ус ариутгал, усан хангамж	18.3	18.4	19.3	20.8	105.0	107.9

Барилгын салбар

Барилга угсралт, их засварын ажил 2018 оны эхний улиралд оны үнээр 248.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 45.2 (22.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр

Барилгын төрөл	2015 I-III	2016 I-III	2017 I-III	2018* I-III	2017 I-III	2018* I-III
	тэрбум төгрөг				хувь	
Барилга угсралт, их засварын ажил	157.6	216.0	202.8	248.0	93.9	122.3
Орон сууцны барилга	57.3	77.2	67.2	23.4	87.1	34.8
Орон сууцны бус барилга	75.3	89.6	120.3	176.7	134.4	146.8
Инженерийн барилга, байгууламж	22.6	47.3	13.3	42.6	28.2	319.7
Их засварын ажил	2.3	2.0	2.0	5.3	97.7	271.3

Зураг 9. Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, импорт

Барилга угсралт, их засварын ажил 2018 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 22.3 хувиар өссөн бол барилгын материалын үйлдвэрлэл оны үнээр 80.3 хувиар, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт 97.1 хувиар нэмэгдсэн байна.



Бөөний болон жижиглэн худалдааны салбар

Бөөний болон жижиглэн худалдаа (дотоод худалдаа)-ны нийт борлуулалт 2018 оны эхний улиралд 3.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 537.4 (19.6%) тэрбум төгрөгөөр өслөө.


Импортын хэмжээ 2018 оны эхний улиралд 1.1 тэрбум сая америк долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 354.3 (45.6%) сая америк доллараар нэмэгдсэн байна. Эрдэс бүтээгдэхүүний импорт 86.6 сая америк доллар, үүнээс дизелийн түлш 54.2 сая америк доллар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги 75.8 сая америк доллараар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 57.7 сая америк доллараар, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлсийнх 43.3 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 10. Дотоод худалдааны борлуулалт, импортын хэмжээ

	Дотоод худалдааны борлуулалт, тэрбум төгрөг						Импорт, сая америк доллар					
	2015	2016	2017	2018*	<u>2017</u> 2016	<u>2018*</u> 2017	2015	2016	2017	2018	<u>2017</u> 2016	<u>2018*</u> 2017
I-III	2 237.2	2 137.9	2 744.8	3 282.2	128.4	119.6	701.7	599.1	776.2	1 130.5	129.6	145.6
I-VI	5 205.7	5 297.0	6 419.6		121.2		1 838.7	1 499.1	1 924.5		128.4	
I-IX	9 157.6	8 291.7	10 194.7		123.0		2 856.8	2 448.0	3 124.7		127.6	
I-XII	13 526.6	13 199.2	15 629.0		118.4		3 797.2	3 358.1	4 337.3		129.2	

Зураг 10. Дотоод худалдааны борлуулалт, импортын хэмжээ

Бөөний болон жижиглэн худалдааны салбар нь манай эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг салбарын нэг билээ. Уг салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2018 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 0.8 пунктийг хангасан байна.



Тээврийн салбар

Бүх төрлийн тээврээр 2018 оны эхний улиралд 14.0 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 1.7 (13.6%) сая тонноор өссөн байна.


Төмөр замаар 2018 оны эхний улиралд 6.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 1.4 (28.5%) сая тонноор өссөн байна.

Хүснэгт 11. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2015 I-III	2016 I-III	2017 I-III	2018*I-III	<u>2016 I-III</u>	<u>2017 I-III</u>	<u>2018*I-III</u>
	2015 I-III	2016 I-III	2017 I-III	2018*I-III	2015 I-III	2016 I-III	2017 I-III
	Шилжүүлсэн сая тонн км				хувь		
Бүх төрлийн тээвэр	3 367.4	3 501.5	4 591.0	5 382.3	104.0	131.1	117.2
Авто тээвэр	779.1	660.1	1 767.3	1 579.8	84.7	267.7	89.4
Төмөр замын тээвэр	2 564.5	2 819.5	2 800.6	3 771.3	109.9	99.3	134.7
Агаарын тээвэр	23.7	21.9	23.1	31.2	92.3	105.6	134.8
	Тээсэн ачаа, мянган тонн				хувь		
Бүх төрлийн тээвэр	7 863.8	7 006.7	12 310.0	13 985.5	89.1	175.7	113.6
Авто тээвэр	3 713.4	2 605.0	7 507.0	7 811.9	70.2	288.2	104.1
Төмөр замын тээвэр	4 149.7	4 401.1	4 802.4	6 172.9	106.1	109.1	128.5
Агаарын тээвэр	0.6	0.6	0.6	0.7	98.8	99.2	116.1

Зураг 11. Тээврийн салбарын орлого

Авто тээврийн орлого 2018 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 1.2 (1.0%) тэрбум төгрөгөөр, төмөр замын тээвэр 33.7 (31.9%) тэрбум төгрөгөөр, агаарын тээвэр 6.3 (9.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.



Шуудан, мэдээлэл, холбооны салбар

Шуудан, холбооны салбарын нийт орлого 2018 оны эхний улиралд 210.1 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 27.5 (15.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 12. Шуудан, холбооны салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2015 I-III	2016 I-III	2017 I-III	2018*I-III	<u>2016 I-III</u>	<u>2017 I-III</u>	<u>2018*I-III</u>
	2015 I-III	2016 I-III	2017 I-III	2018*I-III	2015 I-III	2016 I-III	2017 I-III
					хувь		
Нийт орлого, оны үнээр, тэрбум төг	171.2	169.1	182.6	210.1	98.8	108.0	115.1
Хүн амаас орсон орлого, тэрбум төг	130.5	119.6	123.3	132.7	91.6	103.1	107.6
Суурин утасны цэгийн тоо, мян.ш	235.1	251.5	275.2	306.1	107.0	109.4	111.2
Үүрэн утас хэрэглэгчид, мян.хүн	3 523.5	2 994.4	3 558.1	3 628.8	85.0	118.8	102.0
Утасгүй холбооны тоо	876	594	479	502	67.8	80.6	104.8
Кабелийн телевиз хэрэглэгчид, мян.хүн	348.3	379.3	422.6	446.5	108.9	111.4	105.7

Үйлчилгээний бусад салбар

Үйлчилгээний бусад салбарт зочид буудал, нийтийн хоол; санхүү, даатгал; үл хөдлөх хөрөнгө; мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа; захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал; боловсрол; эрүүл мэнд, нийгмийн халамж; урлаг, үзвэр, тоглоом наадам; үйлчилгээний бусад үйл ажиллагаа зэрэг салбарыг оруулна.

Үйлчилгээний бусад салбарын нийт нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2018 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 1.5 пунктийг бүрдүүлжээ.

➤ Зочид буудал, нийтийн хоолны үйл ажиллагаа

Зочид буудал, нийтийн хоолны салбарын нийт орлого 2018 оны эхний улиралд 111.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 23.4 (26.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд рестораны орлого 28.5 (87.9%) тэрбум төгрөгөөр, баарны орлого 1.4 (65.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 13. Зочид буудал, нийтийн хоолны салбарын орлого, оны үнээр

	2015	2016	2017	2018*	<u>2016</u>	<u>2017</u>	<u>2018*</u>
	тэрбум төгрөг				хувь		
	2015	2016	2017	2018*	2015	2016	2017
I-III	65.2	65.2	88.0	111.4	100.0	134.9	126.6
IV-VI	84.3	101.3	113.3		120.2	111.9	
VII-IX	113.9	118.3	146.8		103.9	124.1	
IX-XII	76.4	82.3	113.4		107.8	137.8	
I-XII	339.7	367.1	461.5		108.1	125.7	

➤ Санхүү, даатгалын салбар

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 3 дугаар сарын эцэст 14.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.5 (11.5%) их наяд төгрөгөөр өсжээ. Нийт хадгаламжийн хэмжээ 2018 оны 3 дугаар сарын эцэст 11.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (29.0%) их наяд төгрөгөөр өсжээ.

Хүснэгт 14. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, хугацааны эцэст

Үзүүлэлтүүд	2015 III	2016 III	2017 III	2018* III	<u>2016 III</u>	<u>2017 III</u>	<u>2018*III</u>
					2015 III	2016 III	2017 III
					хувь		
Зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум төгрөг	12 273.6	11 835.5	12 678.5	14 130.2	96.4	107.1	111.5
Хугацаа хэтэрсэн зээл, тэрбум төгрөг	559.6	965.1	995.1	935.9	172.4	103.1	94.1
Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх %	4.6	8.2	7.8	6.6	-	-	-
Чанаргүй зээл, тэрбум төгрөг	703.0	967.9	1 035.5	1 231.8	137.7	107.0	119.0

Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх %	5.7	8.2	8.2	8.7	-	-	-
Хадгаламж, тэрбум төгрөг	7 369.0	7 571.0	8 811.6	11 369.5	102.7	116.4	129.0
Төгрөг	5 187.7	5 467.3	6 464.3	8 856.4	105.4	118.2	137.0
Гадаад валют	2 181.4	2 103.6	2 347.4	2 513.2	96.4	111.6	107.1
Хадгаламж & зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ тэрбум төгрөг	19 642.6	19 406.4	21 490.1	25 499.8	98.8	110.7	118.7

➤ Төрийн удирдлага, батлан хамгаалах салбар, төсөвт байгууллага

Үйлчилгээний бусад салбарт орсон мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа; төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал; боловсрол; эрүүл мэнд, нийгмийн халамж; урлаг, үзвэр, тоглоом наадам зэрэг салбарын нэмэгдэл өртгийн дийлэнх хувь нь төсөвт байгууллагын нэмэгдэл өртөг байдаг. Зах зээлийн бус үйл ажиллагаа буюу төсөвт байгууллагын нэмэгдэл өртөг нь ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого болон байгууллагын үндсэн хөрөнгийн хэрэглээнээс бүрдэнэ. Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого өмнөх оны мөн үеэс 2016 оны эхний улиралд 3.3 хувиар, 2017 оны эхний улиралд 3.7 хувиар нэмэгдсэн бол 2018 оны эхний улиралд 1.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 15. Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого

Орлогын төрөл	2015 I-III	2016 I-III	2017 I-III	2018 I-III	<u>2016 I-III</u>	<u>2017 I-III</u>	<u>2018 I-III</u>
	2015 I-III	2016 I-III	2017 I-III	2018 I-III	2015 I-III	2016 I-III	2017 I-III
	тэрбум төгрөг				хувь		
Цалин, хөлс, түүнтэй адилтгах орлого	399.7	412.9	428.2	435.6	103.3	103.7	101.7
Нийгмийн даатгалын шимтгэл	36.7	37.6	38.0	41.9	102.5	101.1	110.3
Бүгд	436.4	450.5	466.2	477.5	103.2	103.5	102.4

➤ Бүтээгдэхүүний татвар, татаас

Бүтээгдэхүүний татвараас татаасыг хассан дүн буюу бүтээгдэхүүний цэвэр татвар нь үнэлгээний үзүүлэлт бөгөөд үндсэн үнээрх ДНБ, бүтээгдэхүүний цэвэр татварын нийлбэрээр зах зээлийн үнээрх /худалдан авагчийн үнээрх/ ДНБ-ийг тооцно. Бүтээгдэхүүний татварын гүйцэтгэл нь бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үйл ажиллагаатай нягт уялдаатай байдаг. Бүтээгдэхүүний татварт нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний тусгай зориулалтын орлого, гадаад худалдааны татварыг оруулна. Харин бүтээгдэхүүний татааст эрчим хүчний татаас, нийтийн тээврийн татаас, улаанбуудай, махны татаас орно.

Бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2018 оны эхний улиралд 409.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 1.9 пунктийг бүрдүүлжээ. Үүнд нэмэгдсэн өртгийн албан татвар (оны үнээр) 26.3 хувь, онцгой албан татвар (оны үнээр) 64.5 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

2. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ

2.1. ДНБ, оны үнээр

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ оны үнээр 2018 оны эхний улиралд 6.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 864.6 (15.6%) тэрбум төгрөгөөр өслөө.

Хүснэгт 16. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, оны үнээр

Бүрэлдэхүүн	2015 I-III	2016 ¹ I-III	2017* I-III	2018* I-III	$\frac{2017^* I-III}{2016^1 I-III}$	$\frac{2018^* I-III}{2017^* I-III}$
	тэрбум төгрөг				хувь	
ДНБ	4 559.8	4 736.1	5 556.1	6 420.7	117.3	115.6
Эцсийн хэрэглээ	3 677.5	3 755.6	3 844.6	4 407.2	102.4	114.6
Өрхийн аж ахуй, ӨУАББ-ын эцсийн хэрэглээний зардал ²	3 006.9	2 977.4	3 118.0	3 598.5	104.7	115.4
Төрийн байгууллагын эцсийн хэрэглээний зардал	670.6	778.2	726.6	808.7	93.4	111.3
Хөрөнгийн нийт хуримтлал	567.3	815.4	1 596.9	2 223.2	195.8	139.2
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	584.3	663.9	911.7	1 491.1	137.3	163.6
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ³	- 17.0	151.5	685.2	732.1	452.2	106.8
Цэвэр экспорт	315.0	165.0	114.6	- 209.7	69.5	- 182.9
Экспорт	2 300.2	2 155.9	3 417.4	3 806.5	158.5	111.4
Импорт	1 985.1	1 990.9	3 302.7	4 016.2	165.9	121.6


2. Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

3. Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлалыг оруулсан.

ДНБ, оны үнээр, 2018 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар өсөхөд үндсэн хөрөнгийн нийт хуримтлал 579.4 (63.6%) тэрбум төгрөгөөр, өрхийн аж ахуй болон ӨУАББ-ын эцсийн хэрэглээний зардал 480.5 (15.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөллөө.

Зураг 12. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий бүтэц, дүнд эзлэх хувиар

ДНБ-д 2018 оны эхний улиралд эцсийн хэрэглээ 68.6 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 34.6 хувь, цэвэр экспорт (-3.2) хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс хөрөнгийн нийт хуримтлал 5.9 пунктээр өсөж, харин эцсийн хэрэглээ 0.6 пункт, цэвэр экспорт 5.3 пунктээр буурсан байна.



Өрхийн хэрэглээ 2018 оны эхний улиралд нэмэгдэж, бодит дүнгээр 15.4 хувиар өсөв.

3.1. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны эхний улиралд 3.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 188.1 (6.0%) тэрбум төгрөгөөр өслөө.

Хүснэгт 17. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

Бүрэлдэхүүн	2015 I-III	2016 ¹ I-III	2017* I-III	2018* I-III	<u>2017* I-III</u> 2016 ¹ I-III	<u>2018* I-III</u> 2017* I-III
	тэрбум төгрөг				хувь	
ДНБ	2 934.0	3 024.0	3 149.1	3 337.1	104.1	106.0
Эцсийн хэрэглээ	2 418.0	2 492.0	2 513.0	2 734.1	100.8	108.8
Өрхийн аж ахуй, ӨҮАББ-ын эцсийн хэрэглээний зардал ²	1 972.7	1 969.0	2 010.6	2 203.2	102.1	109.6
Төрийн байгууллагын эцсийн хэрэглээний зардал	445.3	523.0	502.4	531.0	96.1	105.7
Хөрөнгийн нийт хуримтлал	394.9	513.2	1 062.3	1 369.6	207.0	128.9
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	427.4	418.7	631.8	935.6	150.9	148.1
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ³	- 32.4	94.5	430.6	433.9	455.5	100.8
Цэвэр экспорт	121.0	18.8	- 426.3	- 766.6	-	-
Экспорт	1 977.4	2 003.4	2 725.9	3 232.6	136.1	118.6
Импорт	1 856.4	1 984.6	3 152.1	3 999.1	158.8	126.9


2. Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

3. Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлалыг оруулсан.

ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 6.0 хувиар өсөхөд үндсэн хөрөнгийн нийт хуримтлал 303.9 (48.1%) тэрбум төгрөг, өрхийн аж ахуй болон ӨҮАББ-ын эцсийн хэрэглээний зардал 192.6 (9.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 13. ДНБ-ий өсөлтөд бүрэлдэхүүн хэсгүүдийн оролцоо (пункт)

ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 6.0 хувийн өсөлтийн 7.0 пунктийг эцсийн хэрэглээ, 9.8 пунктийг хөрөнгийн нийт хуримтлал, 16.1 пунктийг экспорт, (-26.9) пунктийг импорт бүрдүүлжээ.



Хүснэгт 18. Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2015 I-III	2016 I-III	2017 I-III	2018* I-III	2018* I-III 2017 I-III
	тэрбум төгрөг				хувь
ДНБ, оны үнээр	4 643.5	4 737.2	5 707.8	6 626.2	116.1
ДНБ, 2010 оны үнээр	2 852.8	2 937.3	3 059.7	3 247.7	106.1
ДНБ-ий бодит өсөлт, бууралт, % (өмнөх оны мөн үеийнхээс)	104.2	103.0	104.2	106.1	-
ХҮҮИ, өмнөх оны мөн үеэс,%	9.3	1.7	2.5	6.6	-
Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж	1 228.5	1 095.2	1 504.2	1 810.9	120.4
Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээл	1 373.0	1 710.9	1 759.2	1 836.6	104.4
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	- 144.6	- 615.7	- 255.1	- 25.8	10.1
Мөнгө M1, хугацааны эцэст	1 445.9	1 583.7	2 124.9	2 778.1	130.7
Мөнгө M2, хугацааны эцэст	9 902.3	10 112.4	12 259.3	16 072.3	131.1
Зээлийн өрийн үлдэгдэл, хугацааны эцэст	12 273.6	11 835.5	12 678.5	14 130.2	111.5
Хадгаламжийн нийт хэмжээ, хугацааны эцэст	7 369.0	7 571.0	8 811.6	11 369.5	129.0
АҮ-ийн нийт үйлдвэрлэл	1 762.5	1 805.9	2 688.9	3 273.2	121.7
Уул уурхай	1 131.6	1 200.5	1 962.2	2 362.5	120.4
Уул уурхайн бус	630.9	605.4	726.7	910.7	125.3
Барилга угсралт, их засварын ажил	157.6	216.0	202.8	248.0	122.3
Худалдааны борлуулалт	2 237.2	2 137.9	2 744.8	3 282.2	119.6
Шуудан, холбооны орлого	171.2	169.1	182.6	210.1	115.1
Тээврийн нийт орлого	222.4	225.2	291.8	333.0	114.1
Шилжүүлсэн сая тонн км	3 367.4	3 501.5	4 591.0	5 382.3	117.2
Авто тээвэр	779.1	660.1	1 767.3	1 579.8	89.4
Төмөр замын тээвэр	2 564.5	2 819.5	2 800.6	3 771.3	134.7
Агаарын тээвэр	23.7	21.9	23.1	31.2	134.8
Тээсэн ачаа, мянган тонн	7 863.8	7 006.7	12 310.0	13 985.5	113.6
Авто тээвэр	3 713.4	2 605.0	7 507.0	7 811.9	104.1
Төмөр замын тээвэр	4 149.7	4 401.1	4 802.4	6 172.9	128.5
Агаарын тээвэр	0.6	0.6	0.6	0.7	116.1
Зочид буудал, нийтийн хоолны салбарын нийт орлого	65.2	65.2	88.0	111.4	126.6
Гадаад худалдаа, сая америк доллар					
Нийт эргэлт	1 779.4	1 558.0	2 076.1	2 612.9	125.9
Экспорт	1 077.7	959.0	1 299.9	1 482.4	114.0
Импорт	701.7	599.1	776.2	1 130.5	145.6
Тэнцэл	376.0	359.9	523.7	351.9	67.2
Бүтээгдэхүүний татвар					
НӨАТ	218.0	227.7	301.4	380.9	126.4
Онцгой татвар	126.5	128.9	100.0	164.6	164.6
Гадаад худалдааны татвар	56.5	54.6	86.3	124.7	144.5
Нүүрс:					
Олборлолт, мянган тонн	5 619.8	5 346.3	11 698.1	11 197.6	95.7
Экспорт, мянган тонн	3 244.6	3 270.7	8 137.5	6 769.0	83.2